

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэрэндорж	Дугаар	L089
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Баян-Овоо
Төрсөн газар	Баян Овоо сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Далтын шүтээн, Баруун гуутын хийд, Лаансын Ганжуурын хийд, Зүүн гуутын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭБО 113, СБТЦ 060, БСТЦ 063, СБТЦ 059
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Далтын шүтээн, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Зүүн гуутын хийд,
Баруун гуутын хийд, Лаансын Ганжуурын хийд

Баян овоо нутагт Жавхлантын хийд, Далтын шүтээн, Зүүн Гуут гэж 3 хийд байсан байна. Энэ талаар мөн өөр хийд байсан талаар таны сонссон юм байна уу?

Би 1938 онд энд ирсэн. 10 настай байсан. Миний эцэг лам ,гавж хүн байсан. Урд Баян-Овоо гэдэг уулын ард Ар шанд гэж бий. Аав маань тэнд нямба хийдэг тийм хүн байсан. Одоо ч тэр суурь дов нь байдаг би тэнд очиж байдаг. Тэнд бол хийд байгаагүй юм. Зөвхөн өөрөө бол хоёр нүдгүй болсон. Тэгээд миний дээд талын ахыг дэргэдээ аваад Ар шанд гэдгийн тэнд асруулсан. Одоогийн Сүхбаатар аймгийн Түмэнцогтын нутагт Лаансын хийд гэж байсан. Тэр бол Баян -Уулаас баруун тийш 10-аад км-т бий. Бариа тавианы үед чинь тэр хийдийн дуган сүмийг нураагаад энэ Баян-Овоо сумын төв дээр хоршооны склад барьсан. Тэрнээс өөрийг бол би

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

мэдэхгүй. Миний мэддэг хийдүүдийг бол та нар бүртгэчихсэн юм байна. Чүлтэм энэ тэр хэлсэн юм байгаа биз. Энэ зүүнтээ чинь Далтын хийд гэж байсан даа.

-Далтын хийд багаахан хурал байсан байх?

Тэгэхлээр Далтын хийд гэдэг чинь Цагаан нуурын баруухан талд байсан гэдэг. Лаансын хийд гэж байсан даа. Би тэнд 5,6 настайд аав ээжтэйгээ очиж Майдар хүртэл эргэж байсан.Тэр цавын будаа мудааг нь идэж л байсан. Том тогооны дэргэд зогсоод. Тэрний баруун хойно, хийдээс баруун хойно суварга байсан. Тэрнийг бариа тавианы үед нураасан. Тэнд бол Майдар энэ тэр эргэдэг хийд байсан. Тэр хийд бол Баян-Овоогийн түүхэнд бол байх ёстой хийд. Тэгэхдээ Баян-Овоо сум энд 1937, 38 оны үед нүүгээд ирсэн болохлоор зэрэг тэр нутаг нь одоо Сүхбаатар аймгийнх. Гэхдээ тэр Лаансын хийд бол Сүхбаатар аймгийн түүхэнд байхгүй л байх даа. Баян-Овоо сумын лам нар тэндээс баригдсан.

-Хуучин Баян овоо чинь зүүн Гуут дээрээ байрлаж байсан юмуу ?

Баян-Овоо сум чинь Баян-Овооноосоо зүүхэн хойно Хөндлөн ухаа гэдэг газарт байрлаж байсан юм.

-Хөндлөн ухаа гэдэг газар чинь Зүүн Гуут нь юм байна лээ?

Зүүн Гуут нь гэж байна уу?

-Тийм ээ. Баруун Гуут нь болохоор бас нэг хийд байсан юм байна лээ. Баруун Гуутад Чүлтэм гуай хурж байсан юм байна лээ.

Зүүн Гуут чинь Холбоогийн тэнд гэж ярьдаггүй билүү?

Зүүн Гуутыг чинь Хошуу Бургасны тэнд гэж хэлдэг.

-Баруун Гуут нь Хошуу бургасны тэнд. Зүүн Гуут нь Хөндлөн ухаад байсан юм байна лээ.

Тэгэхлээр Хөндлөн ухаа гэдэг чинь Түмэнцогтын уурхайн, одоогийн Түмэнцогтын сангийн аж ахуйн зүүн хойно баруунтшаа, зүүнтшаа бол Хөндлөн ухаа бий. Тэр чинь Баян-Овоо сумынхаа уулынхаа зүүхан ард. Одоо Түмэнцогтын баруун урдхан дээр. Тэнд чинь наадмаа хийдэг байсан. Би морь унадаг байсан. Зүүн хойноосоо давхидаг. Сумынхаа захиргааны баруугаар давхидаг байсан юм.

-Баруун Гуутын хийд маань Түмэнцогтдоо орж байгаа юм уу?

Баруун Гуутын хийд бол Баян-Овоо сумд хамаарахгүй. Түмэнцогтдоо орно. Түмэнцогтын сангийн аж ахуйгаас 3, 4-хэн км зайтай одоо тэр ухаа толгод бий. Тэнд манай нэг ах Буурал Пүрэвжав гэж байсан. Тэр хүн тэндхийн намын үүрийн дарга байсан. Би очиж 1937 онд Баян-овоо сумын төв дээр очиж байсан.

-Зүүн Гуутын хийд гэдэг маань Хөндлөн Ухаа дээрээ биш бол хаана байсан юм бол?

Зүүн Гуутын хийд гэдэг чинь Бичигтийн тэнд Холбоогийн баруунтай хэдэн чулуу, шавар хүрээ энэ тэр байдаг байсан. Тэгэхэд л Зүүн Гуутын хийд энд байсан гэж нутгийн улсууд ярьдаг байсан. Тэгэхлээр Чүлтэм болохоор зэрэг Хөндлөн Ухаад байсан гэж байна уу?

Аль эсвэл байж байгаад нүүсэн юм болов уу?

Тэр Зүүн Гуутын хийд гэдэг, Баян-Овоо сумын хийд гэдэг дээр Баян-Овоо сумын төв дээр 1938 оны бариа тавианы үед манай эцэг тэр Ар Шанднаас баригдахад тэр сум руу ачигдаж байсан юм. Тэгэхээр Баян-Овоо сум

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бол нэг тийм жаахан, шавар амбаар байсан уу, үгүй юу хэдэн гэр байсан. Гочоогийн Цэрэндорж гэдэг хүн сумын дарга нь байсан. Би бол 1935, 36 оны л юм ярьж байна. Тэгэхлээр манайх 1938 оны хавар тэр Баян-Овоо сумын чинь айлууд нүүж энэ Жавхлантын төв дээр ирж буусан юм.

-Тэгэхлээр Зүүн Гуутын хийд байсан дээр сумын төв байж байгаад наашаа нүүж ирсэн байх уу?

Тэгвэл Баян-Овоо сумын чинь төв хоёр нүүсэн болж таарах нь үү? Хөндлөн Ухаа дээр бол яриангүй байж байсан. Чухам сум нь нүүгээд Зүүн Гуут дээр очсон бол би тэрийг мэдэхгүй. Чүлтэм надаас 10 шахуу ах хүн чинь мэдэж байгаа байлгүй дээ.

-Зүүн Гуутын хийд маань Хөндлөн Ухаа дээр байж байгаад нүүсэн юм биш биз дээ?

Тийм л юм байна. Би бол шууд энэ руугаа ирсэн гэж ойлгодог байхгүй юу.

-Тэгэхлээр сумын төв нь Хөндлөн Ухаагаасаа шууд энд ирээд Зүүн Гуутын хийд маань Хөндлөн Ухаад байж байгаад өөр тийшээ нүүсэн юм болов уу?

Тэгсэн байж болох юм.

-Таны хэлж байгаа Зүүн Гуут гэдэг маань газар нь ямарнэртэй газар байна?

Их бага Холбоо гэж бий. Тэрнээс баруун тийшэхнээ бий. Зүүн хойд талд нь Тарний ам гэж бий. Баруун Гуутын хийд чинь Хошуу бургасанд байсан гэхээр Зүүн Гуут нь урагшаа биш, тэрнээсээ зүүн тийшээ л байх ёстой. За тэгээд Гуут нэртэй байгаад сүүлдээ Хөндлөн Ухаа болсон байж магадгүй юм. Тэрийг бол би мэдэхгүй штээ. Тэгэхлээр жинхэнэ Баян-Овоо сум гэдэг чинь урд талдаа байж байгаад нийлсэн юм шүү дээ. Жавхлантшарга аймаг гэж одоогийн Сүхбаатар аймаг 1940 хэдэн онд байгуулагдсан.

-Лаансын хийд хэдэн дугантай, хэр олон ламтай хийд байсан бэ?

Тэрийг би мэдэхгүй. 3 юмуу 2 дугантай байсан байх. Нэлээн ламтай байсан байхаа. Ер нь Баян-Овооны хэлмэгдэлд орсон лам нарын ихэнх нь тэндээс л орсон. Лам нарыг бүхээгтэй машинаар 2,3 дахин ачсан даа. Тэр үед чинь Зис-5 л байсан биз дээ. Бүхээгтэй машин байсан. Лаансын хийдийн лам нарыг бариад явж байна гэдэг байсан. Манай аав тэнд байж байгаад 2 нүдгүй болоод Баян-Овооны Ар шанд гэдэг газар хүүтэйгээ жижиг гэр бариад сууж байсан. Тэгээд Баян-Овоо уулаа Лаансынхаа хийдээс лам нараа авчирч тахиулдаг тийм хүн байсан. Хамгийн сүүлчийн тахилга нь 1937 онд болсон юм даа. Ер нь би лам олон байсан байх гэж бодож байна. Ихээ том хоёр тогоонд цав манзаа хийдэг тийм байсан.

-Хурлынх нь талаар? Хайлан байдаг юм уу? Ямар ямар хурал хурдаг байсан бол?

Тэр бол бүгдийг нь хийж байсан юм гэнэ лээ. Тэр ер нь том хийд байсан байх.

-Дуганууд нь юу юуны чиглэлийн дуган байсан юм бол?

Тэрийг мэдэхгүй.

-Чойр, Манба гээд байсан болов уу?

Одоо тийм л байх даа. Майдар гэж нэг ногоон ногттой морьтой тэргэн дээр хүүхэд л байсан даа. Заримыг нь ч мартсан байна. Энэнээс өөр юм бол хэлэх юм байхгүй. Тэнд манай ах нар, ээжийн дүү нар олон хүн байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Пүрэвийн Жамц гээд хүн байж байгаад нас барсан. Чүлтэм гэлэн гээд эцгийн дүү байсан. Ер нь манай энэ хийдийг мэдэх хүн дууссан юм байна.